

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2024 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК
Захирал: Ж.Баяртуул
Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogrressaudit@gmail.com
Аудитор: Г.Гантуяа
Утас: 99060147, Цахим хаяг: platinumprogrressaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
А.ЗУРГААНЖИН ТАНАА**

2024.02.22 № 05

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Боловсрол, шинжлэх ухааны газар”-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Боловсрол, шинжлэх ухааны газар”-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020075

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,020,472.00</u>	<u>4,412,291.52</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	583,591.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	583,591.52
3121	Төгрөг	-	583,591.52
31218	Ахмадын сангийн харилцах		583,591.52
33	АВЛАГА	80,572.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	80,572.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,939,900.00	3,828,700.00
354	Хангамжийн материал	2,939,900.00	3,828,700.00
35410	Бичиг хэргийн материал	1,327,000.00	941,500.00
35420	Аж ахуйн материал	1,612,900.00	2,887,200.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>363,462,757.86</u>	<u>391,396,358.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	363,462,757.86	391,396,358.29
392	Биет хөрөнгө	308,436,957.74	390,388,358.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	263,446,545.93	263,446,545.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,425,507.95)	(28,816,283.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	36,221,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,687,741.77)	(36,221,075.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,973,123.28	178,454,636.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,662,294.28)	(41,243,857.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,928,700.00	23,384,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,956,942.47)	(4,837,382.88)
393	Биет бус хөрөнгө	55,025,800.12	1,008,000.00
39301	Програм хангамж	3,040,000.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,714,999.88)	(1,300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,608,000.00	1,008,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,907,200.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>366,483,229.86</u>	<u>395,808,649.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>366,483,229.86</u>	<u>395,808,649.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	366,483,229.86	395,808,649.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	251,766,128.90	251,766,128.90
51101	Өмч: - төрийн	251,766,128.90	251,766,128.90
512	Хуримтлагдсан үр дүн	91,617,478.87	120,942,898.82
51210	Өмнөх үеийн үр дүн	(97,804,119.61)	91,617,478.87
51220	Тайлант үеийн үр дүн	189,421,598.48	29,325,419.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,099,622.09	23,099,622.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>366,483,229.86</u>	<u>395,808,649.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,027,607,127.65	1,007,942,242.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	264,409,527.65	187,549,781.15
120	Нийтлэг татварын бус орлого	264,409,527.65	187,549,781.15
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	216,089,076.03	116,330,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	48,320,451.62	71,219,481.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,197,600.00	820,392,461.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	747,031,100.00	775,289,191.52
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	747,031,100.00	775,289,191.52
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,166,500.00	45,103,269.69
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	16,520,829.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,166,500.00	28,582,440.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	827,475,329.21	894,527,430.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	827,475,329.21	894,527,430.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,751,467.21	379,645,218.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,921,913.00	201,756,601.69
210101	Үндсэн цалин	92,548,468.00	103,254,637.07
210102	Нэмэгдэл	17,480,491.00	66,660,629.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,264,000.00	16,705,000.00
210104	Урамшуулал	3,628,954.00	15,136,334.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,859,829.00	25,345,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,919,929.58	17,235,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,335,588.12	2,027,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	987,097.65	1,622,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,209.41	405,580.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,348,004.24	4,055,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,450,124.00	5,380,888.00
210301	Гэрэл, цахилгаан	311,274.00	301,452.00
210302	Түлш, халаалт	2,740,600.00	2,689,036.00
210303	Цэвэр, бохир ус	130,250.00	122,400.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,205,599.02	58,811,350.00
210401	Бичиг хэрэг	3,167,262.00	4,030,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,874,800.00	3,146,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,160.00	224,000.00
210404	Ном, хэвлэл	30,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	177,000.00	341,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,981,511.00	2,358,200.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	24,769,266.02	48,710,550.00
2107	Томилолт, зочны зардал	2,059,400.00	8,056,000.00
210702	Дотоод албан томилолт	2,059,400.00	8,056,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,439,800.00	1,799,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,000.00	227,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,420,200.00	1,251,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	124,500.00	61,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,500.00	9,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	114,700.00	56,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	140,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,814,802.19	78,495,679.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,407,466.60	52,930,171.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,745,200.00	1,258,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,662,135.59	24,307,308.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	570,723,862.00	514,882,212.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	519,940,160.00	514,338,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,300,760.00	229,417,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	385,811,400.00	284,599,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	828,000.00	321,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,783,702.00	543,912.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,783,702.00	543,912.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>200,131,798.44</u>	<u>113,414,811.48</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,710,199.96	84,089,391.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,749,999.96	84,089,391.53
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,960,200.00	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>189,421,598.48</u>	<u>29,325,419.95</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>763,197,600.00</u>	<u>820,392,461.21</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,197,600.00	820,392,461.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	747,031,100.00	775,289,191.52
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	747,031,100.00	775,289,191.52
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,166,500.00	45,103,269.69
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	16,520,829.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,166,500.00	28,582,440.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>764,489,350.00</u>	<u>819,808,869.69</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	764,489,350.00	819,808,869.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,765,488.00	304,926,657.69

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,670,448.00	201,676,029.69
210101	Үндсэн цалин	92,770,644.00	103,254,637.07
210102	Нэмэгдэл	17,473,992.00	66,660,629.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,796,858.00	16,705,000.00
210104	Урамшуулал	3,628,954.00	15,055,762.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,191,866.00	25,345,700.00
210201	Тэтгэврийн даатгал	12,072,133.91	17,235,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,420,673.19	2,027,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,079,418.53	1,622,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	254,520.60	405,580.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,365,119.77	4,055,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,450,124.00	5,380,888.00
210301	Гэрэл, цахилгаан	311,274.00	301,452.00
210302	Түлш, халаалт	2,740,600.00	2,689,036.00
210303	Цэвэр, бохир ус	130,250.00	122,400.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,056,900.00	8,444,600.00
210401	Бичиг хэрэг	2,575,300.00	3,660,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,180,400.00	3,146,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,200.00	224,000.00
210404	Ном, хэвлэл	141,700.00	69,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	696,400.00	341,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,046,900.00	1,003,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	20,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	-	900,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,059,400.00	8,056,000.00
210702	Дотоод албан томилолт	2,059,400.00	8,056,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,726,700.00	1,880,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,000.00	308,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,420,200.00	1,251,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	124,500.00	61,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,500.00	9,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	114,700.00	56,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	286,900.00	140,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,610,050.00	33,243,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,328,850.00	31,145,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,281,200.00	2,098,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	570,723,862.00	514,882,212.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	519,940,160.00	514,338,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,300,760.00	229,417,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	385,811,400.00	284,599,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	828,000.00	321,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,783,702.00	543,912.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,783,702.00	543,912.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1,291,750.00)</u>	<u>583,591.52</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,291,750.00)	583,591.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,291,750.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	583,591.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	(97,804,119.61)	177,061,631.38
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	(97,804,119.61)	177,061,631.38
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	189,421,598.48	189,421,598.48
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	91,617,478.87	366,483,229.86
9	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	91,617,478.87	366,483,229.86
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	91,617,478.87	366,483,229.86
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	29,325,419.95	29,325,419.95
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	120,942,898.82	395,808,649.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	774,705,600.00	774,161,688.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,705,600.00	774,161,688.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,367,300.00	259,823,388.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,325,200.00	196,325,200.00
210101	Үндсэн цалин	102,191,100.00	103,254,637.07
210102	Нэмэгдэл	61,309,800.00	61,309,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,068,000.00	16,705,000.00
210104	Урамшуулал	19,756,300.00	15,055,762.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,540,700.00	24,540,700.00
210201	Тэтгэврийн даатгал	16,687,600.00	16,687,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,300.00	1,963,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,570,600.00	1,570,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	392,700.00	392,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,926,500.00	3,926,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,908,200.00	5,380,888.00
210301	Гэрэл, цахилгаан	447,000.00	301,452.00
210302	Түлш, халаалт	2,834,100.00	2,689,036.00
210303	Цэвэр, бохир ус	359,100.00	122,400.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,396,200.00	4,396,200.00
210401	Бичиг хэрэг	1,384,200.00	1,384,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,374,200.00	1,374,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,000.00	224,000.00
210404	Ном, хэвлэл	69,400.00	69,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	341,300.00	341,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,003,100.00	1,003,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,900,000.00	20,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	900,000.00	900,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,034,000.00	2,034,000.00
210702	Дотоод албан томилолт	2,034,000.00	2,034,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,896,600.00	1,880,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,800.00	308,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,251,900.00	1,251,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	61,000.00	61,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,600.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,000.00	9,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,200.00	56,200.00
210807	Газрын төлбөр	4,500.00	-

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	140,600.00	140,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,366,400.00	4,366,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,268,200.00	2,268,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,098,200.00	2,098,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	514,338,300.00	514,338,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	514,338,300.00	514,338,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	229,417,200.00	229,417,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	284,599,600.00	284,599,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	321,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	774,705,600.00	774,745,279.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	774,705,600.00	774,745,279.52
131001	Улсын төсвөөс санхүүжих	774,705,600.00	774,745,279.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	583,591.52

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	45,103,269.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	45,103,269.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	45,103,269.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	5,350,829.69
210102	Нэмэгдэл	-	5,350,829.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	805,000.00
210201	Тэтгэврийн даатгал	-	547,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	64,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	51,520.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	12,880.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	128,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,048,400.00
210401	Бичиг хэрэг	-	2,276,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,772,400.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	6,022,000.00
210702	Дотоод албан томилолт	-	6,022,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,877,040.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,877,040.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	45,103,269.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	45,103,269.69
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	16,520,829.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	28,582,440.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь "Хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх " гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/150 тоот "Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" захирамжийг шинэчлэн батлуулаагүй, байгууллагын даргын "Байгууллагын орон тоо, бүтэц, цалин тогтоох тухай" тушаалаар 20 орон тоо баталж, Төрийн захиргааны албан тушаалын ажлын байранд 6 орон тоо гэрээгээр, төрийн үйлчилгээний ажлын байранд 2 орон тоо гэрээгээр ажилласан байна.

Говьсүмбэр аймгийн Боловсролын салбарын хэмжээнд ерөнхий боловсролын салбарын хэмжээнд 5 сургууль, 7 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, 2023 онд СӨБ-д 1,707 хүүхэд, ЕБС-д 4,352 хүүхэд суралцаж, нийт 278 багш ажилласан байна.

Боловсролын чанарын үзүүлэлт сайжирч, чанарын үнэлгээгээр улсад байр эзлээгүй, ЭЕШ-ын дундаж оноо 523.6, улсад 5 дугаар байр эзэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгодог бөгөөд зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,325.4 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	583.6	583.6
Авлага	80.6	-	(80.6)
Бараа материал	2,939.9	3,828.7	888.8
Үндсэн хөрөнгө	363,462.7	391,396.3	27,933.6
Нийт хөрөнгө	366,483.2	395,808.6	29,325.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	366,483.2	395,808.6	29,325.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	366,483.2	395,808.6	29,325.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 583.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.
2. Авлагын дансны үлдэгдэл 80.6 мянган төгрөгөөр буурсан.
3. Бараа материалын дансны үлдэгдэл 888.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал үнэ төлбөргүй орлогод авсан, мөн тайлант оны үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой байна.

4. Үндсэн хөрөнгийн өөрчлөлт нь 116,330.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогод авсан, 25,636.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, 109,696.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн, мөн элэгдлийн хэмжээнээс шалтгаалсан байна.
5. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 395,808.6 мянган төгрөг болж 29,325.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 798,705.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 798,705.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа ажил үйлчилгээний зардлыг 23,416.4 мянган төгрөгөөр бууруулж 775,289.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, норматив зардал, томилолтын зардал, бараа үйлчилгээний зардлуудыг бууруулсан зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсөвт тодотгол хийгдээгүй. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 775,289.2 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 775,289.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 774,705.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 543.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 - Сургуулийн өмнөх боловсрол	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	132,455.9	132,455.9	-	100%
2	71802- Ерөнхий боловсрол	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	381,560.9	381,560.9	-	100%
3	71808- Боловсрол, ШУ-	80801-Үндсэн үйл ажиллагааны зардал	260,367.3	259,823.4	543.9	99.9%

	ны бодлого, удирдлага	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	321.5	321.5	-	100%
--	--------------------------	--	-------	-------	---	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Дээрх хүснэгтээс харахад нийт төсвийн 33.6 хувь буюу 260,688.8 мянган төгрөг нь байгууллагын үйл ажиллагааны зориулалттай, 66.4 хувь буюу 514,016.8 мянган төгрөг нь урсгал шилжүүлэг /тэтгэвэр, тэтгэмж/ байна.

Үйл ажиллагаандаа 260,688.8 мянган төгрөгийн төсөвтэйгөөс 259,823.4 мянган төгрөг буюу 99.9 хувийг зарцуулж, 543.9 мянган төгрөг буюу 0.1 хувийг буцаан төвлөрүүлсэн байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Боловсролын ерөнхий газраас унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүйн сургалт, уралдаан, улсын олимпиад зохион байгуулах зардал 13,443.6 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас сорилго шалгалт, Боловсролтой боржигин малчин- 2023 нөлөөллийн арга хэмжээ, Монгол бичиг мину уралдаан, олимпиад, спортын арга хэмжээний зардал 10,240.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлаас орон нутгийн нэмэгдэл цалинд 6,155.8 мянган төгрөг, нийт 45,103.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Платиниум прогресс аудит” ХХК-ний аудитор Г.Гантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 827,475.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,412.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,688.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Үйл ажиллагаандаа 260,688.8 мянган төгрөгийн төсөвтэйгөөс 259,823.4 мянган төгрөг буюу 99.9 хувийг зарцуулж, 543.9 мянган төгрөг буюу 0.1 хувийг буцаан төвлөрүүлсэн байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 34,889.5 мянган төгрөгийн 23 тушаал шийдвэр хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль-ийн 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, гэсэн заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тогтоосон хугацаанд, тушаал шийдвэрийн хуулбарыг www.shilendans.gov.mn цахим санд мэдээлж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайланд аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалт он тулгаж хийгдсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,132.9	3	1,132.9	100
Зөвлөмж	2	3,632.1	2	3,632.1	100
Нийт дүн	5	4,463.1	5	4,463.1	100

Өмнөх оны аудитаар өгсөн батлагдаагүй орон тоонд хавсран ажилласны нэмэгдэл олгосон зөрчил давтагдан гарсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60,659.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,547.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22,186.6 мянган төгрөгийн албан шаардлага, 34,926.1 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/150 тоот “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” захирамжийг шинэчлэн батлуулаагүй, байгууллагын даргын “Байгууллагын орон тоо, бүтэц, цалин тогтоох тухай” тушаалаар цалингийн ангилал, зэрэглэл зөрүүтэй тогтоож 470.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

